



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№80 /524/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.05.18

Цаг үе, үйл явдал

АЛБА ХААГЧИД ӨӨРИЙН ӨМЧЛӨЛИЙН ХАШАА, ЗУСЛАНГИЙН ГАЗАРТАА МОД ТАРИНА



БХЯ-ны харьяа байгууллагууд болон Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын бие бүрэлдэхүүний амьдрах орчноо ногоон, эко хотхон болгоход дэмжлэг үзүүлэх, уриалах зорилгоор салбарын удирдлагууд өнөөдөр 200 офицер, ахлагч, ажилтан албан хаагч, батлан хамгаалах салбараас тэтгэвэр чөлөөнд гарсан ахмадуудын төлөөлд модны суулгац, үрсэлгээ гардууллаа.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийн хүрээнд Монгол Улсын хэмжээнд 5 дугаар сарын 13-20-ны өдрүүдэд мод тарих ажлыг зохион байгуулж байгаатай холбогдуулан Батлан хамгаалах салбарын хамт олон 2023 оны мод тарих, арчлах үйл ажиллагаагаа албан ёсоор ийнхүү эхлүүлж байна.

Энэхүү үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын дарга, бригадын генерал С.Ганбямба болон БХЯ, ЗХЖШ-ын удирдлагын бие бүрэлдэхүүн, ахмад дайчдын төлөөлөл оролцлоо.

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэж, манлайлан оролцож ирсэн бөгөөд энэхүү үндэсний хөдөлгөөний хүрээнд долоон төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, 2030 он гэхэд 27 сая мод тарих томоохон зорилтыг тавиад байгаа билээ.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр уг үйл ажиллагааг нээж хэлсэн үгэндээ Монгол орны нутаг дэвсгэрийн дөнгөж 11,8 хувийг ой мод эзэлдэг хэдий ч энэ хувь жил ирэх тусам буурч байгаагаас гадна сүүлийн 80 жил агаарын температур 2,2 хэмээр нэмэгдэж, хур тунадасны хэмжээ 7-10 дахин буурч, нийт бэлчээрийн 57 хувь нь доройтсон зэрэг сэтгэл эмзэглүүлсэн тоо баримтыг дурдаад ой модоо нөхөн сэргээх, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд батлан хамгаалах, Зэвсэгт хүчний алба хаагчдын идэвх санаачилга, оролцоо хамгаас чухал байгааг онцлолоо.

Ингээд дэлхий, ирээдүй хойч үеийнхээ сайн сайхны төлөө, эх орныхоо ногоон хөгжлийн төлөө, иргэн бүр эрүүл, цэвэр агаараар амьсгалахын төлөө жил бүр улам олон мод тарьж арчлан хамгаалж ургуулахыг салбарынхандаа уриалаад "Тарьсан мод бүхэн нь сайхан ургаж, та бидний амьдралд өнгө нэмж байх болтугай" хэмээн ерөөгөөд хүндэт зочдын хамт ЗХЖШ-ын Материал техникийн газрын Хэмжил зүйн хангалтын мэргэжилтэн дэд хурандаа У.Ганзам, ЗХЖШ-ын Ахмадын хорооны нарийн бичгийн дарга бэлтгэл хурандаа Баатар, Зэвсэгт хүчний нэгдсэн лабораторийн улсын шалгагч ахлагч Ганхүлэг, Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн хошууч Батболд, Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн

ажилтан Энхжаргал нарын таван алба хаагчдад модны үрсэлгээ, суулгацын дээжийг гардуулсан юм.

Энэ дашрамд өгүүлэхэд, манай Батлан хамгаалах салбар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд олон томоохон ажил, үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, 2,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар таван мод үржүүлгийн газрыг нийт 34 га талбайд байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлсэн. Мөн Батлан хамгаалах яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбаруудыг үе шаттайгаар эко хотхон болгох ажлыг эхлүүлж, Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн эх үүсвэр, анги салбарын алба хаагчдын идэвх оролцоонд тулгуурлан 2021-2022 онд Зэвсэгт хүчний дөрвөн ангийг эко хотхон болгож, 12800 ширхэг мод бутыг тарьж, зүлэгжүүлэн зам талбай, гэрэлтүүлэг засвар тохижилтын ажлыг хийж алба хаагчдынхаа ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлсэн юм. Энэ онд Зэвсэгт хүчний 011, 016 дугаар ангийг эко хотхон болгох ажлыг эхлүүлээд байна. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэмжээнд 2022 онд нийт 77985 мод бутыг тарьсан бөгөөд 2023 онд мод үржүүлгийн газруудад үрээр 6,2 сая тарьц, мөчрөөр 166,5 мянган суулгацыг тарьж ургуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Д.ГҮНЖИЛМАА

600 ГАРУЙ ТАМИРЧИН ДАЙЧИД ХУРД ХҮЧ, ЦЭРГИЙН ХЭРГИЙН МЭДЛЭГЭЭ СОРИН ӨРСӨЛДӨНӨ



Зэвсэгт хүчний 2023 оны аварга шалгаруулах цэрэгжлийн буудлага, цэрэг-спортын цогцолбор зуны олон төрөлт, саадын зурвасын тэмцээний нээлт өнөөдөр буюу 5 дугаар сарын 18-ны өдөр Зэвсэгт хүчний Хужирбулан дахь сургалтын төвд боллоо.

Нээлтийн үйл ажиллагаанд

ЗХЖШ-ын СБГ-ын дарга бригадын генерал Г.Болор, Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат тэргүүтэй хүндэт зочид, ЗХЖШ, Төрийн цэргийн командлалуудын удирдлагын төлөөлөл, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн захирагч нар, тамирчин дайчид оролцлоо.

Нээлтэд үеэр өнгөрсөн

жилийн эл тэмцээний аваргууд болох Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн ахлах дэслэгч Б.Төвжаргал, 256 дугаар ангийн ахмад Г.Цэнд-Аюуш нар Монгол Улсын төрийн далбааг мандуулж, хүндэт зочид, тамирчид дайчдаа хүндэтгэл үзүүллээ.

Энэ жилийн цэрэгжлийн спортын аварга шалгаруулах тэмцээнд 40 орчим нэгтгэл, анги, байгууллагын 600 гаруй офицер, ахлагч, цэргийн хугацаат болон гэрээт албаны дайчид оролцож цэрэгжлийн буудлага, цэрэг-спортын цогцолборын зуны олон

төрөлт, саадын зурвас гэсэн гурван төрөлд хурд хүч, авхаалж самбаа, цэргийн хэргийн мэдлэгээ сорин өрсөлдөх юм.

Мөн уг арга хэмжээг тохиолдуулан цэрэгжлийн цол зэргийн болзол хангасан цэргийн алба хаагчдад ЗХЖШ-ын Сургалтын хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ цол зэргийн энгэрийн тэмдэг, үнэмлэхийг гардууллаа.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 17	☁️ -3


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	☁️ 29

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,461	3,464
EUR 🇪🇺	3,750	3,780
CNY 🇨🇳	494	496.50
RUB 🇷🇺	42,70	43.30
JPY 🇯🇵	25.40	25.80
KRW 🇰🇷	2.61	2.62

ЗУРХАЙ



2023.05.18 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 29

ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ УЛААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:

Сүлд тэнэж одно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.11-20.27

Барилдлага:

Хүчин төгсөх

ШҮТЭН БАРИЛДАГА:

Хуран үйлдэхүй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс элзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.



КОРОНАВИРУС ДЭЛХИ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 688,579,069

Эдгэрсэн

Нийт: 660,957,571

Нас барсан

Нийт: 6,876,409

Цахим шууданд

Хурандаа Д.Цог-Эрдэнэ: ТИВ ДЭЛХИЙД СПОРТЫН ЗАРИМ ТӨРЛӨӨР ЦЭРГИЙНХЭН ТҮҮХ БҮТЭЭЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 2023 оны аварга шалгаруулах цэрэгжлийн буудлага, цэрэг-спортын цогцолборын зуны олон төрөлт,саадын зурвасын тэмцээн маргааш буюу 5 дугаар сарын 18-ны өдрөөс эхэлнэ. Тэмцээний онцлог, ач холбогдол болоод сүүлийн үед Зэвсэгт хүчний алба хаагчдын тив дэлхийд гаргаж байгаа амжилтуудын талаар ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэс тодрууллаа.

Тэмцээний бэлтгэл бүрэн хангагдав уу, энэ жилийн гол онцлог нь юунд оршиж байна вэ?

-Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн командлал болон удирдах газар, Зэвсэгт хүчний 40 орчим нэгтгэл, ангийн давхардсан тоогоор 600 орчим цэргийн алба хаагч цэрэгжлийн буудлага, цэрэг-спортын цогцолборын зуны олон төрөлт,саадын зурвас гэсэн гурван төрлөөр өрсөлдөхөөр бэлтгэлээ бүрэн хангаж дууслаа. Тамирчид Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн харьяа Хужирбулан дахь Сургалтын төвд 20 гаруй хоног, түүнээс өмнө нэгтгэл, ангидаа тодорхой хугацаатайгаар бэлтгэгдсэн гэж хэлж болно.

Цэрэгжлийн спорт гэдэг бол мэргэжлийн тамирчин ч юм уу эсвэл спортлог алба хаагчийн л хичээллэдэг, өрсөлддөг, оролцдог тэмцээн биш. Цэргийн хүн болж тангараг өргөсөн л бол энэ төрлүүдийг заавал гүйцэтгэж чаддаг байх ёстой. Тэр утгаараа тэмцээний чансаа жилээс жилд сайжирч, ажлын ачааллаас шалтгаалаад оролцож амждаггүй Зэвсэгт хүчний ангиуд хүртэл тамирчдаа бэлтгэсэн байгаад талархаж байна.

Тэр дундаа сүүлийн жилүүдэд цэрэгжлийн спортоор эрчимтэй хичээллэж, бүр тодорхой амжилтууд үзүүлсэн Зэвсэгт хүчний 232 дугаар анги, барилга-инженерийн анги дотроо уралдаан тэмцээнд тогтмол оролцдог Зэвсэгт хүчний 338 дугаар ангийнхандаа баяр хүргэмээр байна. Мөн алслагдсан аймгаас зорьж ирсэн Зэвсэгт хүчний 325, 327, 331, 336 дугаар ангийнхныг дурдах учиртай.

Энэ жилийн гол онцлог нь бид пракур гэдэг шинэ төрлийг туршилтаар нэмж оруулсан. Энэ нь дэлхий нийтэд хөгжиж байгаа, орчин үеийн залуусын хамгийн их сонирхож хичээллэдэг спортын нэг төрөл. Саадын зурвас болон гимнастикийн элементийн аль алийг нь багтаасан бөгөөд энгийнээр тайлбарлавал саадыг хурдан давах, хурд хийх гэж ойлгож болно. Монгол Улсад дөнгөж хөгжиж байгаа спорт. Бид мэргэжлийн спорт холбоотой нь хамтраад энэ удаагийн саадын зурвасын үед гүйцэтгэх пракурын төрлийг Улсын аварга шалгаруулах тэмцээн хэлбэрээр зохион байгуулна. Ингэхийн тулд энэ спортоор хичээллэдэг тамирчид, оюутнуудад оролцох боломжийг нь хангаж, бэлтгэл сургалтыг нь явуулж дуусаад байна. Мэдээж энэ төрөлд л цөөн тооны оюутан залуус цэргийнхэнтэй хамт оролцоно. Бусад төрөлдөө цэргийнхэн дангаараа өрсөлдөнө.

Нутаглуулж болох эсэхийг нь туршилтаар шийдэх үү?

-Тийм ээ. Бид энэ л зарчмаар Зэвсэгт хүчиндээ туухай өргөлт, гардан тулаан, орс таталтын тэмцээнийг зохион байгуулсан ба амжилт нь та бидний нүдэнд илхнээ байна. Тив дэлхийн хошой аварга, Азийн болон улсын аваргууд та бидний дундаас тодорлоо. Зөвхөн цэргийнхнээ төлөөлөхгүй Монгол Улсыг нэрийг тив дэлхийд цуурайтуулж байна шүү дээ. Тухайлбал, туухай өргөлт байна. 2022 оны Туухай өргөлтийн Азийн аварга шалгаруулах тэмцээнээс ахмад Г.Цолмонхүү (029), Н.Мадигаым (350), мэргэжлийн тамирчин Туяацэцэг нар тус бүр алтан медаль, ОХУ-д суралцаж байгаа сонсогч Э.Буджав хос мөнгөн медаль хүртэж, энэ төрөлд үзүүлэх амжилтын шанг татсан. Дараа нь Э.Буджав залуулаад БНЭУ-д зохион байгуулагдсан Дэлхийн аварга шалгаруулах туухай өргөлтийн тэмцээнээс 68 кг жинд түлхэлттэй

болон огцом өргөлтөөр хошой аварга болж байх жишээтэй. Э.Буджав бол мэргэжлийн тамирчин биш хичээл сургалтынхаа хажуугаар сонирхож хичээллэдэг цэргийн алба хаагч.

Хамгийн сүүлд гэхэд энэ сарын эхээр Киргизстан Улсад зохион байгуулагдсан Азийн аварга шалгаруулах туухай өргөлтийн тэмцээнээс манай цэргийн алба хаагчид 11 алт, 11 мөнгө, 4 хүрэл медаль хүртлээ.

Манай улсад Азийн аваргаас нэг дор 11 алтан медальтан төрсөн тохиолдол байдаг болов уу?

-Нэг төрөлд ийм олон аварга төрсөн талаар би лав сонсож байгаагүй юм байна. Бараг байхгүй байх. Дээр хэлсэнчлэн амжилт гаргаж байгаа хоёр дахь спортын төрөл нь гардан тулаан. Бас л Зэвсэгт хүчинд "нутаглуулж", алба хаагчдаа бэлтгэж, тэмцээн уралдаан зохион байгуулж ирсэн. Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн жирийн нэгэн алба хаагч, дэслэгч Б.Наадам ажлынхаа хажуугаар хичээллэж, гардан тулааны хамгийн хүнд төрлөөр дэлхийн аваргын хос алтан медальтан боллоо. Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамц цар тахлын амаргүй үед Ховдоос Дорнод хүртэл 46 хоног тасралтгүй гүйж, Монгол Улсын олон өдрийн ганцаарчилсан гүйлтийн рекордыг тогтоож байх жишээтэй. Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн ахлах ахлагч С.Батцэнгэл сонс эргэлтээр мэргэжлийн тамирчдын хийж чадаагүй гиннесийн амжилтыг бас тогтоолоо. Ингээд нэрлээд байвал маш олон байна.

Энэ нь юу хэлж байна вэ гэхээр Зэвсэгт хүчний биеийн тамир, цэрэгжлийн спорт зөв гольдролоороо хөгжиж байгааг илтгэнэ. Мэргэжлийн тамирчид биш атлаа ийм амжилт үзүүлж байгаа нь цэргийн хүний тэсвэр хатуужил, эр зоригтой холбоотой, хоёрдугаарт монгол хүн өөрийгөө дайчилж чадвал асар их нөөц бололцоо байдгийг харуулж байгаа хэрэг.

Нэг жишээ татахад орс таталтын тэмцээн Монгол Улсад хөгжөөд 15-16 жил болж байгаа байх. Цэргийнхний үйл ажиллагаа бүхэн багаар гүйцэтгэдэг учраас багийн спортод амжилтад үзүүлэх магадлал өндөр гээд орс таталтын тэмцээнийг дотооддоо зохион байгуулж эхэлсэн. Харин ердөө хэдхэн хоногийн өмнө Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид улсын аварга болж чадлаа шүү дээ. Ердөө нэгхэн жилийн түрүүч, байлдагч нар ийм бахдам амжилт үзүүлнэ гэдэг бол тэдэнд чиглэсэн сургалт бэлтгэл сайн байгааг илтгэнэ хэмээн ам бардам хэлэх байна.

Туухай өргөлтийн Азийн аваргын медальтнууд болон орс таталтын улсын аваргууддаа хүндэтгэл үзүүлнэ гэсэн. Энэ тухайд?

-Тавдугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдах Зэвсэгт хүчний 2023 оны аварга шалгаруулах цэрэгжлийн буудлага, цэрэг-спортын цогцолборын зуны олон төрөлт, саадын зурвасын тэмцээний нээлтийн үеэр хүндэтгэл үзүүлж, шагнал гардуулна. ЗХЖШ-ын удирдлагууд Азийн аваргын медальтнуудад спортын зэрэг цол олгож, орс таталтын аваргууддаа медаль гардуулж, баяр хүргэнэ.

Ахмад Д.БОЛОР

“ЗАЛУУ ҮЕ-ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ” СЭДВЭЭР СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, ЗХУ-ын Маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар анги Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор зохион байгуулагдах “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицерууд”-ын чуулга уулзалтыг угтаж Монгол Улсын ирээдүй болсон залуу үеийн төлөөлөл буюу Дорнод аймгийн Хэрлэн сумын ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч сэтгэлгээг нь бадрах, төлөвшүүлэх зорилгоор “Залуу үе-Эх орны ирээдүй” сэдэвт сургалт, сурталчилгааны ажлыг сургуулийн орчинд нь явууллаа.

Энэхүү арга хэмжээний хүрээнд ахлах ангийн сурагчдыг ангийн байрлалд хүлээн авч, урлагийн хэсэгчилсэн тоглолт, гардан жагсаалын үзүүлэх тоглолт, буудлагын зэвсэглэлийн үзэсгэлэнг сонирхууллаа.

Хошууч Э.МӨНХБАСАХ

АЛБА ХААГЧДАД ЧИГЛЭСЭН ЭРХ ЗҮЙН СУРГАЛТУУДЫГ ЯВУУЛЛАА



Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн бие бүрэлдэхүүнд хууль, эрх зүйн мэдлэг олгох, зөвлөгөө өгөх зорилгоор энэ сарын 16-ны өдөр Булган аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийнхэн сургалт зохион байгууллаа.

Булган аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн С.Амараар ахлуулсан хуульчид “Зөрчлийн тухай хууль”, “Авлига, ашиг сонирхол, зөрчил”, “Хөдөлмөрийн маргаан” зэрэг хүний амьдралд тохиолддог эрхийн зөрчил, маргааны асуудлаар мэдлэг мэдээлэл өгсөн цаг үеэ олсон чухал сургалт болж чадсан юм.

Мөн цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг багаас нь суулгаж зорилгоор “Аав, ээжийн ажил” арга хэмжээг зохион байгуулж, Булган

аймгийн Хялганат тосгоны “Хараацай” цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 30 гаруй хүүхдэд усчин дайчдын үйл ажиллагааг сонирхууллаа. Тус арга хэмжээний үеэр зэвсэглэл техник, химийн багаж хэрэгслийг дэлгэн, гардан тулааны үзүүлэх тоглолт өргөн барьсанд багачууд сэтгэгдэл өндөр байлаа.

Тавдугаар дугаар сарын 12-ны өдөр Булган аймагт Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Цагдаагийн албаны туг, Сүхбаатарын болон Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Дотоодын цэргийн байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээнд ангийн бие бүрэлдэхүүний төлөөлөл оролцож, гардан тулааны үзүүлэх тоглолтыг толилууллаа.

Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ

“ЦЭРГИЙН МАНЛАЙЛАЛЫН НОМЛОЛ”-ЫГ БОЛОВСРУУЛЖ БАЙНА



Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “Монгол Улс мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг бүрдүүлж бэхжүүлнэ” гэж заасны дагуу бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах үйл ажиллагааны чиглэлээр “Цэргийн манлайллын номлол”-ын төслийг боловсруулах ажлын хэсэг ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдон энэ сарын 12-ны өдрөөс 16-ны өдрүүдэд ажиллалаа.

Тус ажлын хэсэг нь цэргийн манлайллын талаарх ойлголт сэтгэлгээг нэгтгэх, Монгол цэргийн манлайллын үнэт зүйл, үзэл санаа, зарчим, арга замын нэгдмэл ойлголтыг бий болгох, цэргийн алба хаагчдын бүтээлч сэтгэлгээ, эерэг нөлөөллийг урамшуулан дэмжих зэрэг агуулга

бүхий цэргийн манлайллын бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж байна.

Энэхүү бодлогын баримт бичиг батлагдсанаар цэргийн алба хаагчдын албандаа хандах хандлага, итгэл үнэмшил, ёс зүй, мэдлэг боловсрол, ур чадвар, бүтээлч сэтгэхүй дээшилж, бусдаас суралцаж, бусдад нөлөөлөх нөлөөлөл нэмэгдсэнээр Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадвар төдийгүй улс орны хөгжил, нийгмийн төлөвшилд оруулах манлайллын эерэг нөлөөлөл нэмэгдэх юм.

Дээрх ажлын хэсэгт ЗХЖШ-ын бүтцийн нэгжүүд, Төрлийн цэргийн командлалууд, Зэвсэгт хүчний ангиуд, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн зарим офицер, ахлагч нар багтсан юм.

Ахмад Б.БАЛЖИННЯМ

Гэрэл зураг түүх өгүүлнэ



Цэрэгт мордсон ахтайгаа уулзаж буй хүү Гэрэл зургийг О.МӨНХБАТ